



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/08/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70273204 Цахим хаяг: [tsaranchimeg@audit.gov.mn](mailto:tsaranchimeg@audit.gov.mn)

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
3. Аудитын тайлан .....	10
3.1 Ерөнхий зүйл .....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Залруулсан алдаа .....	16
4.4 Зөвлөмж .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
УМЭЕГ	Улсын Мал эмнэлгийн ерөнхий газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.22 № 01/43  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ТӨВ АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН  
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БОЛДБААТАР ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

19020211

D 2022/2022 он/ALBAN BICHIG

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>166,378,121.53</u></b>	<b><u>120,995,876.46</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	20,000,000.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	20,000,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	20,000,000.00	-
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	-	7,200,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	7,200,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	146,378,121.53	113,795,876.46
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	136,790,711.53	97,983,911.46
35110	Тусгай зориулалттай материал	98,952,416.38	82,456,724.00
35130	Эм боох материал	37,838,295.15	15,527,187.46
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	9,587,410.00	15,811,965.00
35410	Бичиг хэргийн материал	4,461,760.00	5,566,015.00
35420	Аж ахуйн материал	1,744,850.00	2,174,150.00
35430	Сэлбэг хэрэгсэл	697,300.00	1,324,300.00
35440	Түлш, шатах тослох материал	2,360,000.00	5,774,000.00
35450	Барилгын засварын материал	71,500.00	81,500.00
35470	Бусад хангамжийн материал	252,000.00	892,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1,440,929,101.44</u></b>	<b><u>1,201,694,707.52</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,440,929,101.44	1,201,694,707.52
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,383,604,101.59	1,144,941,707.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	515,507,943.16	554,372,793.16
39202	Хуримтлагдсан элэгдэл	(6,857,880.59)	(27,595,543.42)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	263,582,896.67	222,634,124.15
39204	Хуримтлагдсан элэгдэл	(115,178,669.10)	(97,544,349.90)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,358,322,215.28	1,356,068,513.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	(667,332,737.27)	(889,779,328.90)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,919,597.34	43,919,597.34
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,359,263.90)	(17,134,098.27)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	57,324,999.85	56,752,999.81
39301	Програм хангамж	2,860,000.00	2,860,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(660,000.15)	(1,232,000.19)
39303	Бусад биет бус хөрөнгө	55,125,000.00	55,125,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1,607,307,222.97</u></b>	<b><u>1,322,690,583.98</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1,607,307,222.97</u></b>	<b><u>1,322,690,583.98</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,607,307,222.97	1,322,690,583.98
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,607,307,222.97	1,322,690,583.98
51210	Өмнөх үеийн үр дүн	493,980,335.71	1,607,307,222.97
51220	Тайлант үеийн үр дүн	1,113,326,887.26	(284,616,638.99)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1,607,307,222.97</u></b>	<b><u>1,322,690,583.98</u></b>

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,681,074,772.24</b>	<b>4,084,435,899.35</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,433,217,202.24</b>	<b>2,144,154,782.75</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	2,433,217,202.24	2,144,154,782.75
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,433,217,202.24	2,144,154,782.75
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,015,200.00	85,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,431,202,002.24	2,144,069,782.75
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,247,857,570.00</b>	<b>1,940,281,116.60</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	901,742,700.00	1,341,152,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	901,742,700.00	1,341,152,000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	346,114,870.00	599,129,116.60
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц	-	4,331,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс	346,114,870.00	571,500,290.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	-	23,297,826.60
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,567,747,884.98</b>	<b>4,369,052,538.34</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,567,747,884.98</b>	<b>4,369,052,538.34</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,526,017,277.70	4,280,486,814.84
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	210,849,600.00	732,630,168.70
210101	Үндсэн цалин	136,359,600.00	553,790,083.66
210102	Нэмэгдэл	61,684,100.00	125,919,120.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,805,900.00	33,037,700.00
210104	Урамшуулал	-	19,883,264.51
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	28,464,600.00	96,271,461.05
210201	Тэтгэврийн даатгал	20,030,700.00	66,771,150.08
210202	Тэтгэмжийн даатгал	2,108,400.00	7,493,514.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,686,800.00	5,942,813.45
210204	Ажилгүйдлийн даатгал	421,700.00	1,414,694.64
210205	Эрүүл мэндийн даатгал	4,217,000.00	14,649,288.58
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	22,257,371.00	19,661,297.75
210301	Гэрэл, цахилгаан	7,299,300.00	5,305,842.00
210302	Түлш, халаалт	13,984,585.00	13,392,359.75
210303	Цэвэр, бохир ус	973,486.00	963,096.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	30,183,597.50	69,741,371.36
210401	Бичиг хэрэг	7,769,490.00	6,849,895.00
210402	Тээвэр, шатахуун	18,840,390.00	20,730,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,674,497.50	2,381,043.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	899,220.00	1,280,030.00
210408	Бараа материал актальсны зардал	-	7,443,323.36
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	31,056,480.00
2105	<b>Нормативт зардал</b>	1,233,982,379.15	2,070,565,333.71
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,230,588,429.15	2,068,461,863.71
210502	Хоол, хунс	3,258,950.00	2,103,470.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,544,608.00	5,242,760.00
210604	Урсгал засвар	1,544,608.00	5,242,760.00
2107	<b>Томиллолт, зочны зардал</b>	16,761,700.00	20,578,000.00
210702	Дотоод албан томиллолт	16,761,700.00	20,578,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,</b>	843,402,816.22	933,806,522.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	840,651,366.22	904,412,350.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,560,950.00	1,567,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,000.00	331,086.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	87,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	3,600,000.00
210807	Газрын төлбөр	92,500.00	275,000.00
210813	Бусад зардал /ТӨҮГ/	-	23,034,086.60
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	138,570,605.83	331,989,899.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	32,989,357.23	46,321,565.75
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	206,090.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	105,581,248.60	285,462,243.92
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	41,730,607.28	88,565,723.50
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	34,519,300.00	539,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	205,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,659,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,655,000.00	539,200.00
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	7,211,307.28	88,026,523.50
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,211,307.28	88,026,523.50
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>1,113,326,887.26</b>	<b>(284,616,638.99)</b>
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>1,113,326,887.26</b>	<b>(284,616,638.99)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /						
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	-	-	493,980,335.71	-	493,980,335.71
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>493,980,335.71</b>	-	<b>493,980,335.71</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	1,113,326,887.26	-	1,113,326,887.26
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>1,607,307,222.97</b>	-	<b>1,607,307,222.97</b>
D01	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>1,607,307,222.97</b>	-	<b>1,607,307,222.97</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>1,607,307,222.97</b>	-	<b>1,607,307,222.97</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(284,616,638.99)	-	(284,616,638.99)
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>1,322,690,583.98</b>	-	<b>1,322,690,583.98</b>

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын тайлан

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

		/Төгрөгөөр/	
Дансны	Үзүүлэлт	Өмнөх оны	Тайлант оны
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,255,975,270.00</b>	<b>1,940,366,116.60</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>2,015,200.00</b>	<b>85,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>2,015,200.00</b>	<b>85,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,015,200.00	85,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,015,200.00	85,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,253,960,070.00</b>	<b>1,940,281,116.60</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>901,742,700.00</b>	<b>1,341,152,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	901,742,700.00	1,341,152,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>352,217,370.00</b>	<b>599,129,116.60</b>
131103	ЗГНХ ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс	-	4,331,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод	352,217,370.00	571,500,290.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	-	23,297,826.60
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,241,757,270.00</b>	<b>1,933,003,116.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,241,757,270.00</b>	<b>1,933,003,116.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,200,026,662.72</b>	<b>1,844,437,392.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>210,849,600.00</b>	<b>732,630,168.70</b>
210101	Үндсэн цалин	136,359,600.00	553,816,583.66
210102	Нэмэгдэл	61,684,100.00	125,919,120.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,805,900.00	33,011,200.00
210104	Урамшуулал	-	19,883,264.51
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,464,600.00</b>	<b>96,271,461.05</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,030,700.00	66,833,555.48
210202	Тэтгэмжийн даатгал	2,108,400.00	7,512,763.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,686,800.00	5,861,160.00
210204	Ажилгүйдлийн даатгал	421,700.00	1,414,694.64
210205	Эрүүл мэндийн даатгал	4,217,000.00	14,649,287.86
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>22,977,371.00</b>	<b>20,741,297.75</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,299,300.00	5,305,842.00
210302	Түлш, халаалт	14,704,585.00	14,472,359.75
210303	Цэвэр, бохир ус	973,486.00	963,096.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>31,694,297.50</b>	<b>33,425,083.00</b>
210401	Бичиг хэрэг	8,308,330.00	6,986,650.00
210402	Тээвэр, шатахуун	19,562,780.00	23,064,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,743,797.50	2,447,543.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,079,390.00	926,290.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>7,034,650.00</b>	<b>1,937,060.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,391,200.00	520,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,643,450.00	1,417,060.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,255,830.00</b>	<b>7,427,140.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	592,000.00	120,450.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,350,000.00	-
210604	Урсгал засвар	1,313,830.00	7,306,690.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>16,761,700.00</b>	<b>20,578,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	16,761,700.00	20,578,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>871,511,196.22</b>	<b>926,528,032.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	868,709,746.22	889,933,860.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,560,950.00	1,567,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	178,000.00	331,086.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	87,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	142,500.00	275,000.00
210813	Бусад зардал	-	23,034,086.60
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,477,418.00</b>	<b>4,899,150.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,477,418.00	4,693,060.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	206,090.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>41,730,607.28</b>	<b>88,565,723.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>34,519,300.00</b>	<b>539,200.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	205,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	32,659,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,655,000.00	539,200.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>7,211,307.28</b>	<b>88,026,523.50</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,211,307.28	88,026,523.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>14,218,000.00</b>	<b>7,363,000.60</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>14,218,000.00</b>	<b>7,363,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>14,218,000.00</b>	<b>7,363,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>14,218,000.00</b>	<b>7,363,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,218,000.00	7,363,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН</b>	<b>(14,218,000.00)</b>	<b>(7,363,000.00)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн н	Үзүүлэлт	Өмнөх оны		/ төгрөгөөр / Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>903,742,700.00</b>	<b>896,546,592.72</b>	<b>1,341,152,000.00</b>	<b>1,254,044,056.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>903,742,700.00</b>	<b>896,546,592.72</b>	<b>1,341,152,000.00</b>	<b>1,254,044,056.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>869,204,400.00</b>	<b>862,027,292.72</b>	<b>1,340,612,800.00</b>	<b>1,253,504,856.50</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	210,849,600.00	210,849,600.00	811,932,200.00	732,630,168.70
210101	Үндсэн цалин	136,359,600.00	136,359,600.00	607,974,000.00	553,816,583.66
210102	Нэмэгдэл	61,684,100.00	61,684,100.00	134,845,600.00	125,919,120.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,805,900.00	12,805,900.00	39,112,600.00	33,011,200.00
210104	Урамшуулал	-	-	30,000,000.00	19,883,264.51
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлө</b>	28,464,600.00	28,464,600.00	99,523,800.00	96,271,461.05
210201	Тэтгэрийн даатгал	20,030,700.00	20,030,700.00	68,244,200.00	66,833,555.48
210202	Тэтгэмжийн даатгал	2,108,400.00	2,108,400.00	8,069,900.00	7,512,763.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,686,800.00	1,686,800.00	6,255,900.00	5,861,160.00
210204	Ажилгүйдлийн даатгал	421,700.00	421,700.00	1,813,900.00	1,414,694.64
210205	Эрүүл мэндийн даатгал	4,217,000.00	4,217,000.00	15,139,900.00	14,649,287.86
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,472,100.00	22,977,371.00	21,556,900.00	20,741,297.75
210301	Гэрэл, цахилгаан	7,299,300.00	7,299,300.00	4,978,600.00	5,305,842.00
210302	Түлш, халаалт	15,530,500.00	14,704,585.00	15,190,400.00	14,472,359.75
210303	Цэвэр, бохир ус	1,642,300.00	973,486.00	1,387,900.00	963,096.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	29,999,800.00	27,361,517.50	28,905,600.00	25,439,483.00
210401	Бичиг хэрэг	10,078,600.00	8,308,330.00	8,566,700.00	6,986,650.00
210402	Тээвэр, шатахуун	16,871,900.00	15,230,000.00	15,081,200.00	15,079,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,937,400.00	2,743,797.50	4,321,800.00	2,447,543.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,111,900.00	1,079,390.00	935,900.00	926,290.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	7,036,400.00	7,034,650.00	2,050,100.00	1,937,060.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,391,300.00	5,391,200.00	633,000.00	520,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,645,100.00	1,643,450.00	1,417,100.00	1,417,060.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	16,933,300.00	15,573,830.00	14,812,600.00	14,790,140.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,269,400.00	9,910,000.00	7,505,400.00	7,483,450.00
210604	Урсгал засвар	1,313,900.00	1,313,830.00	7,307,200.00	7,306,690.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	236,700.00	236,700.00	4,189,400.00	4,185,500.00
210702	Дотоод албан томилолт	236,700.00	236,700.00	4,189,400.00	4,185,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал</b>	546,215,200.00	545,352,546.22	352,740,500.00	352,610,596.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	542,033,100.00	541,451,096.22	339,163,400.00	339,050,510.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоо	500,000.00	432,000.00	500,000.00	500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,567,600.00	1,560,950.00	1,567,600.00	1,567,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	346,500.00	178,000.00	346,500.00	331,086.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00	88,000.00	87,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00	10,800,000.00	10,800,000.00
210807	Газрын төлбөр	180,000.00	142,500.00	275,000.00	275,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,996,700.00	4,176,478.00	4,901,700.00	4,899,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,262,700.00	4,176,478.00	4,695,600.00	4,693,060.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	734,000.00	-	206,100.00	206,090.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,538,300.00</b>	<b>34,519,300.00</b>	<b>539,200.00</b>	<b>539,200.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>34,538,300.00</b>	<b>34,519,300.00</b>	<b>539,200.00</b>	<b>539,200.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,674,000.00	1,655,000.00	539,200.00	539,200.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>901,742,700.00</b>	<b>894,531,392.72</b>	<b>1,341,152,000.00</b>	<b>1,341,152,000.00</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>901,742,700.00</b>	<b>894,531,392.72</b>	<b>1,341,152,000.00</b>	<b>1,341,152,000.00</b>
122005	Орон нутгийн төсвөөс	901,742,700.00	894,531,392.72	1,341,152,000.00	1,341,152,000.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-	-	-
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>83.00</b>	<b>65.00</b>	<b>82.00</b>	<b>65.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
<b>62</b>	<b>АЖИЛЛАГАСАДЫН ТОО</b>	<b>83.00</b>	<b>65.00</b>	<b>82.00</b>	<b>65.00</b>
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	62.00	44.00	60.00	43.00
620003	Үйлчлэх ажилтан	20.00	20.00	21.00	21.00

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>352,217,370.00</b>	<b>575,261,450.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>352,217,370.00</b>	<b>575,261,450.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	352,217,370.00	575,261,450.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,332,780.00	7,985,600.00
210402	Тээвэр, шатахуун	4,332,780.00	7,985,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	16,525,000.00	16,392,500.00
210702	Дотоод албан томилолт	16,525,000.00	16,392,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	331,058,650.00	550,883,350.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	331,058,650.00	550,883,350.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	300,940.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,940.00	-
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>833,580.00</b>
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		833,580.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	352,217,370.00	599,129,116.60
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	352,217,370.00	599,129,116.60
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4,331,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	352,217,370.00	571,500,290.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		23,297,826.60
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн хөрөнгийн зарцуулалттай холбоотой анхан шатны баримтын бүрдүүлэлт болох ө баримт, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Саранчимэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Төв аймгийн Мал эмнэлгийн газар нь мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл, аюулгүй байдлыг баталгаажуулах чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн байгууллага юм.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/01 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналт шалгалт явуулах ажлын хэсгийг байгуулж шалгалт явуулах хуваарийг баталсан байна.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын дотоод хяналтын ажлын хэсэг нь хэлтэс, тасаг, хэсгүүдэд 23 үзүүлэлтээр дотоод хяналт хийх төлөвлөгөө гаргасны дагуу шалгалт хийж, шалгалтын дүнг хэлэлцүүлэн илэрсэн зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг өгч биелэлтийг тооцож ажилласан байна.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд Улсын Мал эмнэлгийн ерөнхий газраас болон аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас шалгалт хийгдээгүй байна.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшин 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 4,005,094.5 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 60,076.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75,0 хувиар буюу 45,057.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын төлөвлөх үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн мэдээллээр тооцсон тул гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогоос дахин тооцлоо.

Гүйцэтгэлийн үе шатанд шинэчлэн тогтоосон материаллаг байдлын түвшин 60,359.4 мянган төгрөг, энэ нь төлөвлөлтийн үе шатнаас 283.0 мянган төгрөгөөр өссөн

байна. Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 45,269.5 мянган төгрөгөөр тогтоогдсон байна.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагад мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

#### **Орлого:**

Тус байгууллага 2021 онд улсын төсвөөс 1,341,152.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 599,129.1 мянган төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс хуваарилсан 4,331.0 мянган төгрөг, дээд шатны төсвөөс хуваарилсан 571,500.3 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 23,297.8 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 85.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 2,144,069.8 мянган төгрөг нийт 4,084,435.9 мянган төгрөг өмнөх оноос 403,361.1 мянган төгрөгөөр буюу 9,8 хувиар буурсан байна.

#### **Зардал:**

Төв аймгийн Мал эмнэлгийн газар 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 4,369,052.5 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 1,933,003.1 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 1,254,044.1 мянган төгрөг зарцуулсан байна.

#### **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:**

Тус байгууллага төрийн сангийн 100140019005 тоот дансанд 2021 онд 1,341,152.0 мянган төгрөгийн орлого, 1,341,152.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140019405 тоот дансанд 1,198,258.2 мянган төгрөгийн орлого төвлөрч, 1,177.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган.төгрөг/

Төв аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	20,000.0	-	20,000.0
Урьдчилгаа	-	7,200.0	(7,200.0)
Бараа материал	146,378.1	113,795.9	32,582.2
Үндсэн хөрөнгө	1,440,929.1	1,201,694.7	239,234.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,607,307.2</b>	<b>1,322,690.6</b>	<b>284,616.6</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,607,307.2	1,322,690.6	284,616.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,607,307.2</b>	<b>1,322,690.6</b>	<b>284,616.6</b>

Авлагын дансны үлдэгдэл 0 мянган төгрөг болж 20,000.0 мянган төгрөгөөр буурсан нь төслийн хөрөнгөөр хийгдсэн барилга өмнөх онд дуусаагүй байсныг орлого авснаас шалтгаалсан байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 7,200.0 мянган төгрөг болж 7,200.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн төслийн программын дараа оны төлбөрийг урьдчилж төлснөөс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 113,795.8 мянган төгрөг болж 32,582.2 мянган төгрөгөөр буурсан нь УМЭГ-т 31,100.0 мянган төгрөгийн эм боох материал шилжүүлснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,201,694.7 мянган төгрөг болж 239,234.4 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгө акталсан болон элэгдэл зардлаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 7,363.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 38,864.9 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдэж, акталсан 50,564.5 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,322,690.6 мянган төгрөг болж 284,616.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,315,400.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 2,315,400.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 974,248.0 мянган төгрөгөөр бууруулж улсын төсвөөс 1,341,152.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь Мал эмнэлгийн газрын оффисын барилга 987,500.0 мянган төгрөгөөр зардлыг бууруулсантай холбоотой байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,341,152.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,341,152.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,341,152.0 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,254,044.1 мянган төгрөгийг зарцуулж, 87,107.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,254,044.1 мянган төгрөг буюу 87,1 хувьтай байгаа нь орон тоо дутуу ажилласнаас цалин шимтгэлийн зардал 82,554.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Мал эмнэлгийн газар нь тайлант онд Төв аймгийн Онцгой байдлын газраас 3,431.0 мянган төгрөг, Аймгийн Засаг даргын А/473 тоот захирамжаар 900.0 мянган төгрөг, УМЭЕГ-аас 571,500.3 мянган төгрөг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдээс төлбөртэй вакцины орлого 23,297.0 мянган төгрөг нийт 599,128.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ.

Үүнээс түлш, шатахууны зардалд 7,985.6 мянган төгрөг, томилолтын зардалд 16,392.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 573,917.5 мянган төгрөг, төвлөрүүлэх шилжүүлэг 833.6 мянган төгрөг нийт 599,128.3 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төв аймгийн Мал эмнэлгийн газар улсын төсвийн хөрөнгөөр 7,363.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан, УМЭЕГ-аас 18,864.9 мянган төгрөгийн их

засвар/ сайжруулалт/, өмнөх онд төслийн хөрөнгөөр баригдсан 20,000.0 мянган төгрөгийн барилга шилжүүлэн хүлээн авч санхүүгийн тайланд тайлагнасан байна.

Төв аймгийн Мал эмнэлгийн газар тайлант онд Онцгой байдлын газраас 0.7 мянган төгрөгийн бараа материал, Биокомбинат УТҮГ 463,726.8 мянган төгрөг, УМЭЕГ-аас 1,510,017.8 мянган төгрөгийн бусад байгууллагаас эм боох материал, тусгай зориулалтын материал хүлээн авч тайлагнасан байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төсвийн ил тод, дэлгэрэнгүй байдал, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, төсвийн хуваарь, байгууллагын задаргаа, зэрэг мэдээлэл бүхий хэрэглэгчийн эрх дээр суурилсан төсвийн хяналтын нэгдсэн онлайн платформыг <https://www.opengov.mn> ашиглах 1 жил 6 сарын гэрээ байгуулж сарын төлбөрт 600.0 мянган төгрөг зарцуулахаар батлагдсан төсвийн мэдээлэл, технологийн үйлчилгээ гэсэн зардалд нэмэлт өөрчлөлт оруулан 10,800.0 мянган төгрөгийг хуваарилсны дагуу тайлант оны зардалд 3,600.0 мянган төгрөг, дараа оны төлбөрт 7,200.0 мянган төгрөгийг урьдчилж төлсөн байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Бруцеллёз, боом, томуу, галзуу, гахайн мялзан, шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин тарьсан үйлчилгээний хөлсөнд мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд 731,578.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй байна. Тус байгууллага Шилэн дансанд хөрөнгө худалдан авах тухай гэрээнүүдийг байршуулаагүй, 5,000.0 мянган төгрөгөөс дээших зарлагын гүйлгээг бүрэн оруулаагүйг 10 дугаар сарын 11 гүйлгээ 481,100.0 мянган төгрөгийн гүйлгээг мэдээлээгүйг аудитын явцад нөхөн мэдээлсэн байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Төв аймгийн Мал эмнэлгийн газар нь нэмэлт санхүүжилтийн дансаар зарцуулсан 599,128.3 мянган төгрөгийг бусад хууль тогтоомжийн хүрээнд зарцуулан тайлагнасан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим сайтад мэдээллийг хуулийн хугацаанд байршуулж мэдээлэх, өр, авлагыг бүртгэлтэй холбоотой 3 зөвлөмжийг 100.0% хэрэгжүүлэн ажиллаж Төв аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2021 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 79 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Сумдын мал эмнэлгийн тасагт бүртгэлтэй байгаа мал угаалгын зөөврийн ванн дахин тооллого хийх

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 803.814.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 47,815.3 мянган төгрөгийн алдааг залруулж, материаллаг бус 755,999.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, дотоод хяналтын зөрчилд зөвлөмж өгөв.

### **4.1 Залруулсан алдаа**

Тус байгууллага санхүүгийн тайлант оны үр дүнгийн тайланд мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдээс төлбөртэй вакцины орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрсөн 23,297.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн

санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Тайлант онд тус байгууллага нь Юнайтэд прайвет ветеринари клиникс монголиас 17,317.5 мянган төгрөг, Онцгой байдлын газраас 185.0 мянган төгрөгийн тусгай зориулалтын бараа материалын орлогыг дутуу авсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Төсвийн хяналтын нэгдсэн онлайн ашиглах гэрээ байгуулж 2022 оны программ хангамжийн төлбөр 7,200.0 мянган төгрөгийг урьдчилж төлснийг санхүүгийн байдлын тайланд авлагаар тусгалгүй шууд зардал хаасан байна. Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүрэн аккурэл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

#### **4.1 Албан шаардлага**

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулганы дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс зөрүүтэй байгаа нь мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд олгосон үйлчилгээний хөлс болон бусад байгууллагууд нийт 25 байгууллага 755,999.0 мянган төгрөгийн е баримтаар нотлогдохгүй дутуу байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 347 тоот тушаалын 5 дахь заалт, Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 6.5-д заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Дотоод хяналттай холбоотой асуудал

###### 1.1. Илрүүлэлт:

Батлагдсан төлөвлөгөөгөөр 5-н чиглэлээр 23 ажил төлөвлөсөн бөгөөд Захиргаа, санхүүгийн алба, мал, амьтны эрүүл мэндийн алба, Мал эмнэлэг, ариун цэврийн лаборатори, Лүн суман дахь мал эмнэлгийн хяналтын цэг гэсэн 4 алба хамрагдаж сумдын мал эмнэлгийн тасаг хамрагдаагүй, мал эмнэлгийн тасгуудад бүртгэлтэй байгаа хөрөнгөнд хяналт, шалгалт хийгдээгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 4.1-д “Дотоод хяналт шалгалтыг дараахь чиглэлээр зохион байгуулна”, 4.1.5-д “өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт” гэж заасныг болон Санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

###### 1.2. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 4.1.5-д “өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт” хийх гэсэн чиглэлийн дагуу Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөнд хөрөнгийн тооллого болон сумдын мал эмнэлгийн тасгийн хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалд бүртгэлээр тавих хяналт шалгалт руу чиглүүлэн үр дүнтэй ажил зохион байгуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Төв аймгийн Мал эмнэлгийн газар	5	803,814.3	3	47,815.3	0	0	1	755,999.0	1	0